

## АЖИЛ ОЛГОГЧИД ҮЗҮҮЛЭХ ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТ

Дараах нөхцөлийг хангасан Ажил олгогчид ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ:

- Даатгуулагчийг тогтвор суурьшилтай ажиллуулсан;
- Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн;
- Ажилгүйдлийн даатгалын сангаас 3 жил дараалан ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй.

## ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ

Ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн 15 хувиар тооцож, 3 жил тутамд нэг удаа шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ.

## “НИЙГМИЙН ДААТГАЛ” АППЛИКЕЙШНИЙГ ГАР УТСАНДАА ТАТАЖ САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМААР АВАХ БОЛОМЖТОЙ

- Сайн дурын даатгалын гэрээгээ байгуулах, сунгах
- Сайн дурын даатгалын шимтгэлээ төлөх
- Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн мэдээллээ жил, сараар харах, хянах, хэвлэх
- Нийгмийн даатгалын байгууллагаас авсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн мэдээллээ харах
- Санал хүсэлтээ цахимаар илгээж шийдвэрлүүлэх

## ГАР УТАСНААСАА САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХ БОЛОМЖТОЙ

- ✓ Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах
- ✓ Сайн дурын даатгалын шимтгэлээ төлөх
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн мэдээллээ жил, сараар харах, хянах, хэвлэх
- ✓ Нийгмийн даатгалын байгууллагаас авсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн мэдээллээ харах
- ✓ Санал хүсэлтээ цахимаар илгээж шийдвэрлүүлэх

“МИНИЙ ТЭТГЭВРИЙН МӨНГӨН ХУРИМТЛАЛ”-ЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛЭЭ НИЙГМИЙН ДААТГАЛЫН АППЛИКЕЙШН-ЭЭС АВНА УУ!

NDAATGAL 2.0  
*Хувилбар*

ТАНЫ ГАР УТСАНД



ГАР УТАСНЫХАА



НД-ЫН АПП-АА ШИНЭЧЛЭЭРЭЙ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**



АЖИЛГҮЙДЛИЙН  
**ДААТГАЛ**

## АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС

Даатгалуулагчийн төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ
Ажил олгогч	0.5
Даатгуулагч	0.2

### АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГААС

Даатгуулагчид

- Ажилгүйдлийн тэтгэмж олгоно.

Ажил олгогчид

- Шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ.



## АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ

Даатгуулагч ажил олгогчтой тооцоо хийж дууссанаас хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар эсхүл биечлэн өргөдөл гаргана.

### АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ

Даатгуулагчийн сүүлийн дараалсан 9 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дараах хувь хэмжээгээр тооцож олгоно:

Ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа / сараар/	Тэтгэмж бодох хэмжээ / хувиар/
24-59	50
60-119	55
120-179	60
180 ба түүнээс дээш	70

Ажилгүйдлийн тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн олгоно

Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж, албан журмаар даатгуулж эхэлсэн бол тэтгэмж олголт зогсоно.

Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд ажилд орж, албан журмаар шимтгэл төлж эхэлсэнээс хойш 5 сарын дотор ажлаас дахин чөлөөлөгдсөн бол анх тогтоосон ажилгүйдлийн тэтгэмжээс олгогдоогүй тэтгэмжийн үлдсэн хэсгийг олгоно.

### АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВАХ ЭРХ

- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар тасралтгүй төлсөн байх;
- Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг дахин 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн байх.

### АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ОЛГОХ ХУГАЦАА

Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн өдрийн дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр тооцож олгоно;

Нийгмийн даатгалын байгууллага нь ажилгүйдлийн тэтгэмж хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг цахимаар эсхүл биечлэн хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ;

### БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Өргөдөл
- Ажлаас чөлөөлөгдсөн тухай шийдвэр
- Ажилгүй болсноо Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагад бүртгүүлсэн байх. /ejob.gov.mn цахимаар бүртгүүлж болно/